

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/02/НА-СТА-ОНА

ТӨВ ЭРДЭНЭС ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	13
5.2 Албан шаардлага.....	13
5.3 Зөвлөмж	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	14
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	14
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.16 № 01/216
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст 5,893.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй, 29,089.6 мянган төгрөгийн цалин хөлсийг анхан шатны баримтгүй зарцуулсан, 1,464.0 мянган төгрөгийн шатахууныг шууд зардалд бүртгэн тайлагнасан зэрэг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Тасалбар болголт", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь байгуулагдсанаас хойш үйл ажиллагаа явуулаагүй, тайлант онд үйл ажиллагаа явуулж эхэлж байгаа бөгөөд 2022 оны санхүүгийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулаагүй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

G/Архив/Албан бичиг 2023/ А4

19020265

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд үйл ажиллагааг явуулж эхэлж байгаатай холбоотойгоор байгууллагын хэвийн ажиллагааг хангах зорилгоор 80,000.0 мянган төгрөгийн зээл авч, санхүүгийн тайланд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллага нь шилэн дансанд мэдээлбэл зохих 163 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	33,332.65	23,000,960.68
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.6	Бараа материал	58,250.00	-
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	41,877,900.00	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.10	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	41,969,482.65	23,000,960.68
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	-
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
1.3	Нийт хөрөнгийн дүн	41,969,482.65	23,000,960.68
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	4,980,871.73	1,736,837.30
2.1.1.2	Цалингийн өглөг		-
2.1.1.3	Татварын өр	555,200.00	-
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	4,156,800.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	47,792,700.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	53,328,771.73	5,893,637.30
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	79,584,184.43
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	79,584,184.43
2.2	Өр төлбөрийн нийт дүн	53,328,771.73	85,477,821.73
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч	1,000,000.00	1,000,000.00
2.3.1	- төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(12,359,289.08)	(63,476,861.05)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(11,359,289.08)	(62,476,861.05)
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	41,969,482.65	23,000,960.68

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	1,500,000.00	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	39,738,671.97
11	Санхүүгийн зардал	-	2,188,700.00
12	Бусад зардал	10,286,500.00	15,105,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(8,786,500.00)	(57,032,371.97)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(8,786,500.00)	(57,032,371.97)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(8,786,500.00)	(57,032,371.97)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(8,786,500.00)	(57,032,371.97)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-ны үлдэгдэл	1,000,000.00	2,342,010.92	3,342,010.92
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-
3	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	2,342,010.92	3,342,010.92
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(8,786,500.00)	(8,786,500.00)
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-
6	Өмчид гарсан өөрчлөлт			-
7	Зарласан ногдол ашиг		-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
9	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,000,000.00	(6,444,489.08)	(5,444,489.08)
10	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-
11	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	(6,444,489.08)	(5,444,489.08)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(57,032,371.97)	(57,032,371.97)
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-
14	Өмчид гарсан өөрчлөлт			-
15	Зарласан ногдол ашиг			-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
17	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,000,000.00	(63,476,861.05)	(62,476,861.05)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,500,000.00	-
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,500,000.00	-
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	4,808,667.35	57,032,371.97
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,215,300.00	29,089,566.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	5,018,074.42
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	157,100.00	3,240,000.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	600,000.00	1,464,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	2,188,700.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	927,031.55
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,836,267.35	15,105,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,308,667.35)	(57,032,371.97)
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	80,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	80,000,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	80,000,000.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,308,667.35)	22,967,628.03
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	3,342,000.00	33,332.65
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	33,332.65	23,000,960.68

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гадаад худалдаа
- Уул уурхай, ашигт малтмалын чиглэлээр сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Төв аймгийн ИТХ байх бөгөөд компанийн өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгах шийдвэр гаргаж гүйцэтгэлд нь хяналт тавина.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 3 дугаар тогтоолын дагуу байгуулагдаж, хавсралтаар байгууллагын дүрмийг баталсан байна.

Байгууллагын дүрмийн 4.1.1-д заасан аймгийн ИТХ-ын бүрэн эрхийг “Компанийг өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”, 4.2.1-д “Компанийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх” гэж тус тус заасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ”, 16 дугаар зүйлийн 16.2-т “Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана” гэж заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тогтоол “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,968.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	33.3	23,000.9	22,967.6
Авлага	-	-	-
Бараа материал	58.3	-	(58.3)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	41,877.9	-	
Нийт хөрөнгө	41,969.5	23,000.9	(18,968.6)
Богино хугацаат өр төлбөр	53,368.8	5,893.6	(47,475.2)
Урт хугацаат өр төлбөр	-	79,584.1	79,584.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,000.0	1,000.0	-
Хуримтлагдсан ашиг	(12,399.3)	(63,476.8)	(51,077.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	41,969.5	23,000.9	(18,968.6)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөрийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 23,000.9 мянган төгрөг болж 22,967.6 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант оны эцэст касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлгүй, харилцах дансны 23,000.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна. Бараа материалын данс тайлант оны эцэст үлдэгдэлгүй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 5,893.6 мянган төгрөг болж 47,475.2 мянган төгрөгөөр буурсан нь урьдчилж олсон орлогоос шалтгаалсан байна. Тайлант оны эцэст 1,736.8 мянган төгрөгийн дансны өглөг, 4,156.8 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 79,584.1 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд үйл ажиллагаагаа эхлүүлж байгаатай холбоотойгоор зээл авснаас шалтгаалсан байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан алдагдал 63,476.8 мянган төгрөг болж 51,077.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Төв Эрдэнэс ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төв аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 3 дугаар тогтоолоор байгуулагдсан боловч санхүүгийн эх үүсвэргүйгээс сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа явуулаагүй, бүтэц орон тоо, санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх, баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах, нягтлан бодох бүртгэлийг аккурель сууриар хөтөлж, тайлагнахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаа “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр цахимаар ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан зорилтот түвшний нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн байдлын тайланг, суурь үзүүлэлтийг нийт хөрөнгө 41,969.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 629.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 472.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 163 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 163 мэдээллийг огт мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ нь байгуулагдсанаас хойш үйл ажиллагаа явуулаагүй, тайлант онд үйл ажиллагаа явуулж эхэлж байгаа бөгөөд 2022 оны санхүүгийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын өмнөх оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Б	1	2	3	4	5	6
1	Акт	-	-	-	-	-
2	Албан шаардлага	-	-	-	-	-
3	Зөвлөмж	-	-	-	-	-
	Нийт дүн	-	-	-	-	-

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37,911.2 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 5,893.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 32,017.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант оны эцэст 5,893.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Тасалбар болголт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн авлага, өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд анхан шатны баримтгүй 29,089.6 мянган төгрөгийн цалин хөлс, 1,464.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх, баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах.

2. Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 1,464.0 мянган төгрөгийн шатахууныг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэн тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийг аккрузаль сууриар хөтөлж, тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байхгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант оны эцэст 5,893.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй	1	5,893.6			1	5,893.6						
2	Тайлант хугацаанд анхан шатны баримтгүй 29,089.6 мянган төгрөгийн цалин хөлс, 1,464.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан	1	30,553.6					1	30,553.6				
3	Тайлант хугацаанд 1,464.0 мянган төгрөгийн шатахууныг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэн тайлагнасан	1	1,464.0					1	1,464.0				
	Дүн	3	37,911.2			1	5,893.6	2	32,017.6				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансанд мэдээлбэл зохих 163 мэдээллийг огт мэдээлээгүй	1	-			1	-		
	Нийт дүн	1	-			1	-		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn